



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Хамрагдсан байгууллага: СҮХБААТАР АЙМГИЙН УГСААТАН ЗҮЙН МУЗЕЙ
Тайлангийн код: ХШҮДАГ-2026/ДА/03

Улаанбаатар хот

2026 он

АГУУЛГА

АГУУЛГА	1
1. ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Байгууллагын тухай	2
2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ	3
2.1. Аудитын зорилго:	3
2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт	3
2.3. Аудитын арга, аргачлал	4
2.4. Өмнөх шалгалтын талаар	4
3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА.....	5
3.1. Засаглалын удирдлагын талаар.....	5
3.2. Эрсдэлийн удирдлагын талаар	6
3.3. Дотоод хяналтын талаар.....	6
4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР	6
4.1. Төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт;	8
4.2. Төрийн аудитаас 2024 онд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт;	9
4.3. Шилэн дансны тухай хуулийн 2025 оны хэрэгжилт;	10
4.4. Салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалт, үр дүнг.....	11
5. АУДИТЫН ҮР ДҮН	12
6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ	13

1. ТАНИЛЦУУЛГА


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.3 “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа хамаарна”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.2, 7.3, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн А/101 дугаар тушаалаар баталсан “Сүхбаатар аймаг дахь харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх” удирдамжийн дагуу 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн СХШУДАГ-ын дарга Ч.Энх-Амгалан ахалж, тус газрын ахлах шинжээч Ц.Алтанхуяг, шинжээч Г.Шүрэндолгор Сүхбаатар аймгийн Музейн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэлээ.

1.1. Байгууллагын тухай

Сүхбаатар аймгийн музей нь 1949 оны 04-р сарын 15-нд Аймгийн бага хурлын нарийн бичгийн даргын шийдвэрээр Аймгийн захиргааны харьяанд тэр үеийн халуун усны байшингийн нэг өрөөнд “Орон нутаг судлах кабинет” нэртэйгээр байгуулагдаж, 1962 онд музейд зориулан үзэсгэлэнгийн дөрвөн танхимтай нэг давхар байшин барьж ашиглалтад оруулсан байна. Соёлын яамны сайдын 1972 оны тушаалаар “Орон нутгийг судлах музей болж өргөжсөн байна. Орон нутгийг судлах кабинетын анхны эрхлэгчээр шатрын спортын мастер М.Чоён ажиллаж байсан бөгөөд тэрээр ажиллаж байх хугацаандаа төв, хөдөөгүүр явж, үзмэрүүд цуглуулж баяжуулснаар музейн сан хөмрөг бүрдсэн байна. Үүнээс гадна ард иргэд өөрсдөдөө хадгалагдаж байсан үзмэрийг аймгийнхаа музейд үнэгүй бэлэглэдэг байжээ. Музейн үзмэр, сан хөмрөгийн төрлүүдийн онцлогийг харгалзан үзэж, 1992 оноос “Орон нутгийг судлах музей”-г “Угсаатны зүйн музей” болгон дагнан төрөлжүүлсэн. Музейн сан хөмрөгийг түүх, байгаль, угсаатан, шашны төрлийн эд зүйлээр баяжуулж, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэж, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Тус музей нь үзмэрийн 7 танхим, түр үзэсгэлэнгийн 1 танхимтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Сүхбаатар аймгийн соёлын өвийг сурталчлах зорилгоор 1996, 1999, 2003, 2011, 2019 онд Улаанбаатар хотод бие даасан үзэсгэлэнгүүд гаргаж байсан. Мөн ОХУ-ын Чита муж, Агын буриадад 1992 онд 14 хоног, Итали улсын Милан хотод 2002 онд 1,5 жил, Испани улсын хэд хэдэн хотод 2007 онд нэг жилийн хугацаатай үзэсгэлэнг БСШУЯ-тай хамтран гаргаж байсан. Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музей нь бусад музейгээс нутгийн ард түмний алдарт дархчуудын дахин давтагдашгүй шилдэг бүтээлүүдээрээ эрс ялгардаг онцлогтой. 2019 онд 70 жилийн ойгоо угтаж Дарьгангын үе дамжсан дархан Гомбосүрэнгийн Эрдэмбэлэгт захиалга өгч “Дарьганга өв” мөнгөн цомыг урлуулсан. Энэ нь Дарьганга дархчуудаа дэмжих, тэдний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, мөн музейн үзмэр эд өлгийн зүйлийн баяжилт нэмэгдүүлэхэд онцгүй хувь нэмэр оруулжээ. Мөн ойн хүрээнд “Сүхбаатарчуудын өв соёл” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, “Нандин өв” үзмэрийн каталог 1,2, 4 төрлийн “Ил захидал”, Дарьганга мөнгөн урлалын гарын авлага, 2022 онд “Түүх мартаггүй”, 2024 онд “Дарьгангын хөргүүд”, “Үзэмчин угсаатны домог”, “Дарьганга нэрийн учир”, “Торой бандийн домог” буддаг номыг тус тус хэвлүүлэн гаргаж байжээ.

Тус байгууллага нь Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/215 дугаар захирамжаар бүтэц орон тоог 21 ажилтантай байхаар батлуулсан ба 2026 оны 03 дугаар сарын байдлаар 15 ажилтан, албан хаагчтай ажиллаж байна. Албан тушаалын ангилал зэрэглэлийн хувьд ТҮСБ-8, ТҮ-7 ажилтан, албан хаагч байна.

Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музейн бүтэц зохион байгуулалт, орон тоо



Байгууллагын регистрийн дугаар 9051902, үндсэн үйл ажиллагааны 100120035021, рон нутгийн төсвөөс санхүүжих 100120035010 дугаар харилцах дансаар бэлэн, бэлэн бус төлбөр тооцоог хийж иржээ.

Аймгийн Засаг даргын 2013 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/12 дугаар захирамжаар Д.Ариундэлгэр Сүхбаатар аймгийн Угсаатан зүйн музейн захирлыг албан тушаалд томилсон байна. Аудитын хамрах хугацаанд дээрх шийдвэрийн дагуу нэгдүгээр гарын үсгийг Д.Ариундэлгэр, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогчоор 2014 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн Б/13 дугаар тушаалаар томилогдсон Б.Түвшинсайхан нар тус тус зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

Тус байгууллага нь 2025 оны жилийн эцсийн санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлангуудыг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад гарган өгч баталгаажуулсан.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1. Аудитын зорилго:

Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн аудит хийн дүгнэж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, зөвлөмж өгөх байдлаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилго баримтлан ажилласан.

2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Хамарсан хүрээ: Тус байгууллагын 2025 оны жилийн эцсийн байдлаар тасалбар болгон санхүүгийн үйл ажиллагаа (засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, төсөв, төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт, Төрийн аудитын газраас гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн 2024 оны аудитын шийдвэрийн биелэлт, Шилэн дансны тухай хуулийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилт, салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт

санхүүжилтийн зарцуулалтын тайлан, үр дүн)-нд байдалд санхүүгийн дотоод аудитыг гүйцэтгэсэн.

Хязгаарлалт: Дээр дурдсан хүрээгээр энэхүү дотоод аудитыг хязгаарласан болно.

2.3. Аудитын арга, аргачлал

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Соёлын сайдын /хуучин нэрээр/ 2022 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал”-ыг мөрдөж санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн болно.

Аудитад дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур болго. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай;
- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Шилэн дансны тухай хууль;
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль;
- ✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ✓ Соёлын тухай хууль;
- ✓ Музейн тухай хууль;
- ✓ Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль;
- ✓ Бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт.

2.4. Өмнөх шалгалтын талаар

Аймгийн санхүүгийн хяналт, аудитын албаны шалгалтад хамрагдсан байдал

Сүхбаатар аймгийн санхүүгийн хяналт, аудитын албанаас 2023 онд 2021-2022 оны байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагаа төлөвшлийг үнэлж, дүгнэх, Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах захиран зарцуулалтын байдал, өмнөх дотоод аудитын зөвлөмжийн биелэлтийг үнэлэх, үйл ажиллагааны үр дүнгийн байдалд дүгнэлт хийх, шилэн дансны хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын иж бүрдэл, тайлан гаргалтын байдалд Гүйцэтгэлийн аудит хийж 5 асуудлаар зөвлөмж өгсөн байна. Дотоод аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 99 дүгээр албан бичгээр Сүхбаатар аймгийн санхүүгийн хяналт, аудитын албан хүргүүлж ажилласан байна. Тус шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 80%-тай хэрэгжсэн байна.

Тус аудитаар музейн үзмэр, эд өлгийн зүйлсийг хадгалж хадгалж хамгаалах стандартын шаардлага хангахгүй байна. Барилга нурах, гал гарах өндөр эрсдэлтэй, үзмэрийн хэв загвар алдагдах эвдрэх үзмэр, эд өлгийн зүйлс хөнгөрөх, үнэ цэнэ буурах, хэлбэр дүрсээ алдах, музейн эд зүйлс шатах, устаж үгүй болох эрсдэлтэй гэж үзэн Аймгийн засаг дарга болон музейн захиралд музейн шинэ барилгыг бариулах талаар арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн байна. Тус зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна.

3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

Угсаатан зүйн музейн 2025 онд Танхимын үзэсгэлэн 8 дэглэн 3292 үзэгч, боловсролын 9 төрлийн сургалт бэлтгэж ЕБС-ын 1267 сурагч, СӨБ-ийн 559 хүүхэд, насанд хүрэгч /гэр бүл/ 103 хүн нийт 1929 хүнд тус тус хамрагдсан байна.

Угсаатан зүйн музейн сан хөмрөгт сүүлийн 5 жилийн байдлаар 658 ширхэг үзмэр нэмэгдсэн байна.

Соёл спорт аялал жуулчлал залуучуудын сайдын А/253 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/421 дүгээр захирамжаар аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын дарга Б.Золхүүгээр ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдон ТСХДЗ-ийн сан хөмрөгийн улсын тооллогыг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр эхлүүлж Угсаатны зүйн музейн 1829 дэсийн 2800 үзмэр тоологдохоос урьдчилсан байдлаар 1828 дэсийн 2799 ширхэг үзмэр тоологдсон байна. Үзмэр эд өлгийн зүйлийн тулгалт хэмжилт зураг авалт болон программын шивэлт бүрэн дууссан. Тооллогын бэлтгэл ажлыг ханган данснаас хасуулах саналтай 3 дэсийн 3 ширхэг үзмэрийн материалуудыг бүрдүүлэн Соёлын сайд, СӨҮТ болон бусад холбогдох байгууллагад хүргүүлснээр 3 дэсийн 3 ширхэг үзмэрийн шаардлага хангахгүй болсон эд өлгийн зүйлсийг данснаас хасуулан ажиллажээ.

Байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын төлөвлөгөө боловсруулан ажиллажээ. Үүнд: Үндэсний бичгийн мэдлэгийг дээшлүүлэх, цэвэр бичгийн сургалт, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн танилцуулга сургалт, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллаж журам”, “Сүхбаатар аймгийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг хэргийн нөхцөл байдал, анхаарах асуудал”, “Зарим төрлийн гэмт хэрэг, зөрчлийн эрх зүйн зохицуулалт” зэрэг нийт 15-н төрлийн сургалтыг зохион байгуулж албан хаагчдыг хамруулсан байна. Мөн СУИС-н Соёлын сургуульд Соёлын өвийн чиглэлээр бакалаврын зэргийн боловсрол эзэмшүүлэх эчнээ ангид 1 албан хаагчийг суралцуулж байна.

Байгууллагын албан хаагчид Дорноговь аймгийн музей сургалт, судалгааны төвтэй танилцах, Говийн их ноён хутагт Данзанравжаа музей 12 албан хаагч, Дорнод аймгийн музей үзэж туршлага судлахад 3-н албан хаагч, Хөх хотын музейг үзэж туршлага судлахад 6-н албан хаагч, “Туркийн музей-2025” 10 хоногийн хөтөлбөрт 1 албан хаагч хамрагдаж Истанбул хотын 3-н музей 2 ордон, Адъяаман мужийн музей, Шанглиурфа хотын музейтэй танилцаж туршлага судалжээ.

3.1. Засаглалын удирдлагын талаар

Засаглах удирдлага:

Байгууллагын захирлыг аймгийн засаг дарга томилж байна. Тайлант онд Аймгийн засаг даргаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллажээ. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 9 зорилтын хэмжээнд 39 арга хэмжээ төлөвлөгдсөн ба гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 93.8 хувьтай үнэлэгдсэн ба тус үнэлгээгээр аймгийн төсөвт 5 байгууллагаас 1 дүгээр байрт шалгарсан байна.

Сүхбаатар аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газартай 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр 02 дугаар “Хамтран ажиллах гэрээ” байгуулж, тус гэрээнд заасан арга хэмжээний хүрээнд хамтран ажиллажээ. Тус гэрээний хавсралтаар Соёл, урлагийн 3 чиглэлийн 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ. Гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлан гаргаж Сүхбаатар аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт хүргүүлсэн байна.

Хөдөлмөрийн дотоод журмын талаар:

Байгууллагын захирлын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/24 тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг баталсан байна.

Тушаал шийдвэрийн талаар:

Тус байгууллага нь 2025 оны жилийн эцсийн байдлаар улирлын байдлаар үндсэн үйл ажиллагааны чиглэлээр “А” индексийн 50, боловсон хүчний чиглэлээр “Б” индексийн 17, нийт 67 тушаал төлөвлөж гаргасан байна.

Байгууллагын засаглалын талаар ажлын баримт АБ1002-оор 8 асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Давтамжтай буюу 2-р түвшин”-нд байна.

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар

Тус байгууллага нь эрсдэлээ тодорхойлж, үнэлдэггүй.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцын талаар ажлын баримт АБ1003-аар 12 асуулга авч, дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

3.3. Дотоод хяналтын талаар

Байгууллага нь Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг Угсаатан зүйн музейн захирлын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/18 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталжээ. Дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг 2025 оны төлөвлөгөөг байгууллагын захирал батлуулжээ 6 ажил төлөвлөж гүйцэтгэсэн байна.

Дотоод хяналтын байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой хяналт-шинжилгээг төлөвлөж, тайлагнасан, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Дотоод хяналтын үйл явцын талаар ажлын баримт АБ1004-өөр 8 асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 4 чиглэлийн 13 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**Төсвийн төлөвлөлт**

Байгууллагын 2025 оны төсвийн төслийг 626,004.4 мянган төгрөгөөр боловсруулан ССАЖЗЯ -нд хүргүүлсэн.

ССАЖЗЯ - аас тус байгууллагын 2025 оны төсвийг 564,919.0 мянган төгрөгөөр анх баталсан боловч 2025 оны 7 дугаар сард хийгдсэн төсвийн тодотголоор 551,489.5 мянган төгрөг болж 13,429.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Тус байгууллагын 2025 оны урсгал санхүүжилтэд улс, орон нутгийн төсвөөс 1 хөтөлбөр 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 551,489,5 мянган төгрөгийн төсөв батлагдсан.

- Үндсэн үйл ажиллагааны зардалд 520,690.0 мянган төгрөг
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил-7,500.0 мянган төгрөг
- Байр ашиглалтын зардалд 61,217.0 мянган төгрөг
- Засаг даргын дэмжлэг 3,599.0 мянган төгрөг

Тус байгууллагын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,406,059.9 мянган төгрөгөөр өмнөх оноос 56,212.1 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар өссөн байна. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлангаар 855.9 мянган төгрөг авлага, 1,099.5 мянган төгрөгийн өглөгтэй, 84,837.8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 1 /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	27.42	855.98	828.57
Бараа материал	21,096.06	21,496.74	400.68
Үндсэн хөрөнгө	1,328,724.31	1,383,707.20	54,982.89
Нийт хөрөнгө	1,349,847.78	1,406,059.92	56,212.14
Богино хугацаат өр төлбөр	-	1,099.46	1,099.46
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,349,847.78	1,404,960.47	55,112.69
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,349,847.78	1,406,059.92	56,212.14

Бараа материалын дансны үлдэгдэл 21,496.74 мянган төгрөг буюу өмнөх оноос 400.06 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 27,386.48 мянган төгрөгийн бараа материалын худалдан авч, 26,985.80 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,383,707.2 мянган төгрөг болж 54,928.89 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант хугацааны 89,252.41 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө орлогод авч, 21,089.04 мянган төгрөгийн хөрөнгийг зарлагдаж 34,269.51 мянган төгрөгийн цэвэр элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийн 1,099.46 мянган төгрөгийн өглөгтэй байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,404,960.47 мянган төгрөг болж, 55,112.69 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 2025 оны жилийн эцсийн улс, орон нутгийн төсвөөс 629,274.61 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар харуулав.

Байгууллагын 2025 оны жилийн эцсийн байдлаарх төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дүн

Хүснэгт 2 /мянган төгрөг/

№	Орлого, зардлын эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	636,725.60	629,274.61	7,450.99	98.8
801010	Үндсэн үйл ажиллагааны зардал	540,423.40	535,290.21	5,133.19	99.1
802150	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	7,500.00	4,787.50	2,712.50	63.8
808020	Ажил олгогчоос олгох тэтгэмж	3,925.60	3,925.60	0.00	100.0
818550	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	14,770.60	14,723.80	46.80	99.7
836030	Үндсэн үйл ажиллагааны орлого	8,888.90	9,330.40	-441.50	105.0

801110	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	61,217.10	61,217.10	0.00	100.0
II	НИЙТ ЗАРДАЛ	606,777.10	587,614.40	19,162.70	96.8
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	458,360.50	457,507.79	852.71	99.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалын зардал	57,295.10	57,506.04	-210.94	100.4
210301	Гэрэл, цахилгаан	3,849.40	3,849.41	-0.01	100.0
210302	Түлш, халаалт	44,867.70	44,867.69	0.01	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,500.00	2500.00	0.00	100.0
210604	Эд хогшил, урсгал засварын зар	10,000.00	10,000.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	900.00	818.20	81.80	90.9
210402	Тээвэр, шатахуун	450.00	626.90	-176.90	139.3
210403	Шуудан, холбоо, интернэт	900.00	968.50	-68.50	107.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	900.00	886.35	13.65	98.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,908.20	6,868.98	39.22	99.4
210702	Дотоод албан томиллт	1,500.00	1,500.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зарда	13,210.00	12,533.05	676.95	94.9
210801	Эрдэм шинжилгээ, судалгааны зардал	7,500.00	4,787.50	2,712.50	63.8
	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн нэгдсэн зарцуулалт	14,770.60	14,723.79	46.81	99.7
210104	Урамшуулал	1,969.40	1,960.00	9.40	99.5
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	246.20	245.00	1.20	99.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,908.24	5,872.00	36.24	99.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,431.18	4,431.20	-0.02	100.0
213204	Албан хаагчдын нийгмийн асуудал	2,215.59	2,215.59	0.00	100.0

4.1. Төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт

Бараа материалын талаар:

Бараа материал 2025 оны эхэнд 21,096.06 мянган төгрөг, жилийн эцсийн байдлаар 21,496.74 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал

Хүснэгт 3 (мянган төгрөг)

Д/д	Төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Эзлэх хувь
1	Бичиг хэргийн материал	1,192.55	4,305.25	4,466.75	1,031.05	5%
2	Аж ахуйн материал	8,214.88	2,218.68	753.69	9,679.87	45%
3	Шатахуун	50.00	1,457.90	1,507.90	-	0%
4	Эм боох материал	151.00	1,283.05	583.20	850.85	4%
5	Барилгын засварын материал	542.40	10,016.60	10,343.10	215.90	1%
6	Бусад хангамжийн материал	10,945.23	8,105.00	9,331.16	9,719.07	45%

Дүн	21,096.06	27,386.48	26,985.80	21,496.74	100%
-----	-----------	-----------	-----------	-----------	------

Нийт бараа материалын 90 хувийг хангамжийн бараа материал, үлдсэн 10 хувийг бусад бараа материал эзэлж байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 27,386.48 мянган төгрөгийн бараа материалын худалдан авч, 26,985.8 мянган төгрөгийн бараа материалыг шаардах хуудсаар, зарлагын баримт үйлдэж зарцуулан тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

Үндсэн хөрөнгө 2025 оны эхэнд 1,446,761.99 мянган төгрөг, жилийн эцсийн байдлаар 1,514,925.35 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө

Хүснэгт 4(мянган төгрөг)

№	Дансны дугаар	Дансны нэр	Эхний үлдэгдэл дүн	Орлогын дүн	Зарлагын дүн	Эцсийн үлдэгдэл дүн
1	39100	Газар	130,243.00	-	-	130,243.00
2	39201	Барилга, байгууламж, орон сууц	236,074.65	3,578.41	2,089.04	237,564.02
3	39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	117,902.11	4,720.00	2,285.00	120,337.11
4	39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,046.94	17,910.00	16,445.00	54,511.94
5	39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	906,680.29	63,044.00	-	969,724.29
6	39214	Бусад үндсэн хөрөнгө	270.00	-	270.00	-
7	39301	Програм хангамж	2,545.00	-	-	2,545.00
		Нийт дүн	1,446,761.99	89,252.41	21,089.04	1,514,925.36

Нийт хөрөнгийн 64 хувийг музейн түүх дурсгалын эд зүйлс, барилга 16 хувийг, газар 8,6 хувийг, тоног төхөөрөмж 8 хувийг, тавилга эд хогшил 4 хувийг, программ хангамж 0,2 хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд үнэ төлбөргүйгээр буюу хандиваар 63,044.0 мянган төгрөгийн түүх дурсгалын зүйлс авсан ба тус хөрөнгийг үнэлж данс бүртгэлд тусгасан байна. Нийт 89,252.41 мянган төгрөгийн хөрөнгийн данс бүртгэлд тусгаж 21,089.04 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан хөрөнгө байна.

4.2 Төрийн аудитаас 2024 онд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Тус байгууллагын 2024, 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газраас түүвэр аудитад хамрагджээ. Аудитын дүнгээр 2024 онд 1 зөвлөмж, 2025 онд 855.98 мянган төгрөгийн 1 албан шаардлага авсан байна.

Төрийн аудитаас байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар зөвлөмжийн хэрэгжилтийг хянахад биелэлт 100 хувьтай байна.

Аудитын хугацаанд 2025 оны төрийн аудитын албан шаардлагыг хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг батлуулан Үндэсний аудитын газрын цахим системд баталгаажуулав.

Төрийн аудитын байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийн дүн

Хүснэгт 5 (мянган төгрөг)

Шийдвэрийн төрөл	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн товч утга	Мөнгөн дүн	Хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт хувиар
2024 он				
Зөвлөмж	Төсвийн хөрөнгөөр эргэлтийн болон үндсэн хөрөнгө бэлтгэхдээ цахим дэлгүүрт байршсан бараанаас худалдан авалтыг зохион байгуулаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4 дэх /цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно/ заалтыг зөрчсөн байна.		2025 оны батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлан байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах бараа материалыг батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааны журмын дагуу байнгын харилцагч байгууллагуудаас худалдан авч ажиллаж байна. Тайлант хугацаанд бичиг хэрэг, тээвэр шатахуун, БҮТЭЗ, бараа үйлчилгээний бусад зардлаас нийт 3589.4 мян.төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө бэлтгэх худалдан авалт хийгдээгүй.	100%
2025 он				
Албан шаардлага	Татварын байгууллагад ХХОАТ-ыг 555.9 мянган төгрөгөөр илүү шилжүүлж авлага үүссэн. Мөн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүрээнд аймгийн төв номын санд “Дарьганга буддаг ном” нэгжийг нь 5000 төгрөгөөр 60 ширхгийг 300.0 мянган төгрөгөөр нийлүүлсэн боловч төлбөр төлөгдөөгүйн улмаас 300.0 мянган төгрөгийн авлага үүссэн.	855.9	Аудитын явцад хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг батлуулж цахим системд байршуулав. Татварын байгууллагад илүү төлсөн ХХОАТ-ын 555.9 мянган төгрөгийн авлагыг хааж хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	50%
Дүн		855.9		

4.3. Шилэн дансны тухай хуулийн 2025 оны хэрэгжилт

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтын шилэн дансны цахим системд 2025 онд 24 нэр төрлийн 171 мэдээлэл оруулахаас Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 6,129.85 мянган төгрөгийн 8 шийдвэрийг оруулаагүй, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний 5,416.56 мянган төгрөгийн 1 гүйлгээ, нийт 11,546.4 мянган төгрөгийн 9 мэдээллийг мэдээлээгүй байна.

4.4. Салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалт, үр дүн

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/212 дугаар тушаалаар Сүхбаатар аймгийн салбарын 15 байгууллага нийт 176,408.8 мянган төгрөгийн үр дүнд суурилсан санхүүжилтийг авсан байна.

Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн дүн

Хүснэгт 6 (мянган төгрөг)

№	Байгууллагын нэр	2023 он	2024 он	2025 он
1	Уулбаян соёлын төв	6,971.0	5,697.0	10,123.0
2	Түвшинширээ соёлын төв	7,576.0	7,545.0	8,646.0
3	Түмэнцогт соёлын төв	7,432.0	7,906.0	8,290.0
4	Наран соёлын төв	7,031.0	7,910.0	8,076.0
5	Дарьганга соёлын төв	5,370.0	6,746.0	7,730.0
6	Баяндэлгэр соёлын төв	9,534.0	6,599.0	7,657.0
7	Мөнххаан соёлын төв	6,105.0	6,214.0	8,071.0
8	Сүхбаатар соёлын төв	8,899.0	7,358.0	7,149.0
9	Асгат соёлын төв	11,721.0	6,102.0	7,034.0
10	Халзан соёлын төв	3,876.0	6,538.0	6,564.0
11	Онгон соёлын төв	7,287.0	7,930.0	6,276.0
12	Эрдэнэцагаан соёлын төв	7,707.0	7,703.0	4,495.0
13	Жаахан шарга театр	42,345.0	66,183.0	68,347.0
14	Музей	20,280.0	17,505.0	14,771.0
15	Нийтийн номын сан	8,825.0	25,597.0	6,416.0
	Нийт дүн	160,958.2	193,533.0	176,409.6

Угсаатан зүйн музей нь 2025 онд 14,771.0 мянган төгрөгийн үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийг авсан ба тус санхүүжилтээр 5,872.4 мянган төгрөгийн багаж техник хэрэгсэл, 4,431.2 мянган төгрөгийг эрдэм шинжилгээ судалгаанд, 2,215.59 мянган төгрөгийг ажилтан албан хаагчдын нийгмийн баталгаанд, 2,205.0 мянган төгрөгийг ажилтан албан хаагчдын урамшуулалд зарцуулсан байна.

Угсаатан зүйн музей үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн дүнгээр 2023 оны улсын хэмжээнд 7 дугаарт, 2024 онд 17 дугаарт, 2025 онд 18 дугаар жагссан байна. Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн хэмжээ сүүлийн 3 жилийн хэмжээнд буурч байгаа

тул тус нэмэлт санхүүжилтийг олгох журамд заасан шалгуур үзүүлэлтийн сайжруулах шаардлагатай шалгуур үзүүлэлт дээр дүн шинжилгээ хийн анхаарч ажиллахыг зөвлөж байна.

5. АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудал 1.	Анхан шатны баримтын иж бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд бүртгэсэн байна.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: Монгол хэл бичгийн багш Г.Нандинцэцэгтэй "Монгол бичгийн цахим бичвэр сургалт"-ыг зохион байгуулахаар 150.0 мянган төгрөгийн сургалтын гэрээг 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр хийжээ. Гэрээг дүгнэсэн акт байхгүй, сургалт хийсэн тухай тайлан бүхий санхүүгийн анхан шатны баримт байхгүй байна.	
Шалгуур үзүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан: Анхан шатны баримтын иж бүрдлийг хангах ажлын процесс ажил хангалтгүй, үйл ажиллагааны хяналт сул байна.	
Байгууллагад үзүүлэх нөлөө: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй үйлдэл, эс үйлдэл нь байгууллага зөрчил, дутагдал үүсэх эрсдэлтэй.	
Зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журмыг үндэслэн санхүүгийн анхан шатны баримтыг бүрдлийг хангаж ажиллах.	

Илэрсэн асуудал 2.	Байгууллага гэрээнд заасан эрх, үүргээ хэрэгжүүлж ажиллахгүй байна. .
Асуудлын ангилал	Нөлөө багатай
Бодит байдал: Угсаатан зүйн музейн даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/43 дугаар тушаалыг үндэслэж Түүх дурсгалын хөдлөх хөрөнгийн улсын тооллого зохион байгуулах ажлын хүрээнд 2,300.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдалдан авахаар 3673553 регистрийн дугаартай Хавиргын ундарга ХХК-тай "Бараа нийлүүлэх гэрээ"-г 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулжээ. Тус гэрээний 2.1 дахь заалтын дагуу барааг хүлээн авч акт үйлдсэнээр төлбөрийг шилжүүлнэ гэж тохиролцсон боловч барааг хүлээн авсан акт үйлдэгдэлгүй төлбөрийг бүрэн шилжүүлсэн байна.	
Шалгуур үзүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна. Бараа нийлүүлэх гэрээний 2.1 дахь заалтын дагуу барааг хүлээн авч акт үйлдсэнээр төлбөрийг шилжүүлнэ.	
Асуудлын үндсэн шалтгаан: Байгууллага үндсэн хөрөнгө бэлтгэхдээ худалдан авч буй хөрөнгийнхөө чанар, аюулгүй ажиллагаа болон бусад ирээдүйд гарч болох эрсдэлийг зохицуулах баримтжуулалтыг хийж ажиллахгүй байна	

Байгууллагад үзүүлэх нөлөө: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй үйлдэл, эс үйлдэл нь байгууллага зөрчил, дутагдал үүсэх эрсдэлтэй.

Зөвлөмж:

Гэрээнд заасан эрх үүргээ хэрэгжүүлж гэрээг дүгнэж санхүүгийн анхан шатны баримтыг бүрдлийг хангаж ажиллах.

Илэрсэн асуудал 3.	Шилэн дансны цахим хуудсанд 11,546.4 мянган төгрөгийн 9 мэдээллийг мэдээлээгүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: Шилэн дансны бүртгэл хөтлөлтөд хяналт шалгалт хийхэд Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 6,129.85 мянган төгрөгийн 8 шийдвэрийг оруулаагүй, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний 5,416.56 мянган төгрөгийн 1 гүйлгээ, нийт 11,546.4 мянган төгрөгийн 9 мэдээллийг мэдээлээгүй байна.	
Шалгуур үзүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн 4.1.1 дэх заалт мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчимтай нийцэхгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах аргачлал, зааврыг бүрэн хэрэгжүүлээгүй үйлдэл, эс үйлдэл.	
Байгууллагад үзүүлэх нөлөө: Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй болох эрсдэлтэй.	
Зөвлөмж: Зөрчлийг давтан гаргахгүй байх. Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх	

6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Сүхбаатар аймгийн Угсаатан зүйн музейн 2025 оны жилийн эцсийн байдлаарх төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа, дутагдлын үр нөлөө, цаашид үүсэх эрсдэлийг үнэлэн аудитаар илэрсэн асуудлын 66,67% нь нөлөө ихтэй байгаа учир “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Цаашид аудитаар илэрсэн алдаа дутагдалыг залруулах, аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны дотор СХШУДАГ-т албан бичгээр нотлох баримтын хамт ирүүлэхийг мэдэгдье.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

---oO---